

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/32

Сүмбэр сум

“Уянгын хэлхээ” өсвөрийн ёочин хөгжимчдийн
улсын анхдугаар уралдаанд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөрийн 3.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уянгын хэлхээ” өсвөрийн ёочин хөгжимчдийн улсын анхдугаар уралдаанд сурагчдыг оролцуулахыг Хүүхдийн хөгжил, оролцоо хариуцсан мэргэжилтэн /Э.Урантунгалаг/-д даалгасугай.

2. “Уянгын хэлхээ” өсвөрийн ёочин хөгжимчдийн улсын анхдугаар уралдаанд зарцуулагдах 81880 /наян нэгэн мянга найман зуун наян/ төгрөгийг нэмэлт санхүүжилтийн дансны бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас гаргахыг нягтлан бодогч /Д.Оюунцэцэг/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ц.ОЮУНБИЛЭГ

Д:/Бичиг хэрэг /тушаал

421790052